

БАТЛАВ:  
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш. БАЯНМӨНХ



БАТЛАВ:  
ДӨРГӨНЭ БҮРД ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ Д.ОТГОННЯМ



АЖЛЫН ХУВЦАС ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № 60/2022

20<sup>22</sup> оны 05-р сарын 17 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Дөргөнэ бүрд ХХК-ийн захирал Д.Отгонням /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

### Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл

1.1 Нийлүүлэгч нь “Ажлын хувцас” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох нэгдүгээр хавсралтанд заасан нэр төрөл, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

### Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 30 хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

### Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл

3.1 Энэ гэрээний нийт үнэ 30,329,000 /гучин сая гурван зуун хорин есөн мянга/-н төгрөг бөгөөд Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх, тээврийн зардал, НӨАТ бүгд шингэсэн байна.

3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр 15,000,000 /арван таван сая/-н төгрөгийг олгоно.

3.3 Үлдсэн төлбөрийг бараа нийлүүлж дууссан гүйцэтгэлээр олгоно.

3.4 Барааг хүлээн авсаны дараа бараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт, нийлүүлэгчийн нэхэмжлэлийг үндэслэн 90 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн Голомт банк 4605117069 тоот дансанд шилжүүлнэ.

### Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага

4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.

- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3 Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4 Барааг хугацаандаа нийлүүлж чадаагүй тохиолдолд түүнээс гарах хохирлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.
- 4.5 Захиалагчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Амгалан дулааны станц ТӨХК-ийн Цахим худалдан авалт хариуцсан ажилтан Г.Баярчимэг хариуцан ажиллана. Утас-99508224
- 4.6 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Дөргэнэ бүрд ХХК-ийн захирал Д.Отгонням хариуцан ажиллана. Утас-99808956

#### **Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол**

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгчийн шаардлагаар биелүүлэх үүрэгтэй.
- 5.3 Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон үйлдвэрийн доголдолоос гарсан барааны гологдол зэрэг шаардлагад нийцээгүй ажлын хувцасыг буцаан өөрийн зардлаар засаж, залруулах үүрэгтэй.

#### **Зургаа. Бараа хүлээн авах**

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

#### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцөлүүд гарч эхэлсэн тохиолдолд 5 хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

#### **Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

- 8.1 Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.

8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

### Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
АЖ АХУЙ ХАНГАМЖ ЭРХЭЛСЭН ДЭД  
ЗАХИРАЛ Б.УРТНАСАН  
Гарын үсэг:

СЭЭХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧ О.УДВАЛ  
Гарын үсэг:

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г. ЭРДЭНЭБИЛЭГ  
Гарын үсэг:

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
П.ЗОРИГОО  
Гарын үсэг:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г. САРУУЛ  
Гарын үсэг:

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
ЦАХИМ ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН  
АЖИЛТАН  
Г.БАЯРЧИМЭГ  
Гарын үсэг:

Хаяг: Улаанбаатар хот  
Баянзүрх дүүрэг, 8-р хороо, ус 15-1-1  
Утасны дугаар: 77111251 РД: 6021646

### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДӨРГЭНЭ БҮРД ХХК-ИЙН

Д.ОТГОННЯМ

Гарын үсэг:



Хаяг: Улаанбаатар хот: Багануур дүүрэг 5-р хороо  
ЖДҮДТөвийн 203 тоот Утас 99808956  
РД: 4557301

Бараа нийлүүлэх үнийн санал

Д/д	Барааны нэр	Гарал үүслын улс	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Бүгд үнэ /НӨАТ/- тэй
1	Ажлын хувцас /өвлийн/	Монгол	109	Хос	155000	16,895,000.00
2	Ажлын хувцас /зуны/	Монгол	120	Хос	85000	10,200,000.00
3	Сорочкон цамц	Монгол	77	Ширхэг	42000	3,234,000.00
Дүн						30,329,000.00

Амгалан дулааны станц ТӨХК-ийн

Цахим худалдан авалт хариуцсан ажилтан *Д.Баярчимэг* Баярчимэг

Дөргэнэ бүрд ХХК-ний захирал

*Д.Ойртоо* Д.Ойртоо

